



МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН  
УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДУГНЭЛТ

211239 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг.  
Хувьсгалчдын өргөн чөлөө-15, Төр захиргааны II байр  
И-мэйл: ub\_info@inspection.gov.mn,  
Утас: 70111284, Факс: 31-13-77

2012. 04. 05 № 07-11/542

Г Барилгын төлөв байдлын  
тухай

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2012 оны 01-р сарын 18-нд баталсан 01/08 тоот "Мэргэжлийн хяналтын байгууллагын 2012 оны хяналт шалгалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх нэгдсэн удирдамж", Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дэд даргын баталсан 2012 оны 03-р сарын 14-ний өдрийн 02/68 тоот "Соёл урлагийн байгууллагуудын барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний ашиглалтын байдалд хийгдэх нэгдсэн шалгалт хийх удирдамж", Биеийн тамир, спортын газраас 2012 оны 03-р сарын 12-ны өдрийн "Спортын төв ордны ашиглалтын байдлын тухай" 1/234 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу 2012 оны 03-р сарын 29-ний өдөр спортын төв ордны барилгын төлөв байдлыг Биеийн тамир, спортын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Д.Сүх-Очир, аж ахуйн дарга н.Мянганбаяр нарыг байлцуулан шалгалаа.

Сүхбаатар дүүргийн 8-р хороонд байрлах Спортын төв ордны барилгын зураг төслийг 1957 онд БНХАУ-д боловсруулж мөн улсын барилгачид барьж 1958 онд ашиглалтанд оруулсан, барилга нь 110.16x62.96м, 2 жигүүртээ 3 давхар, 1-р болон 2-р давхрын хойд хэсэгт Биеийн тамирын дунд сургууль, хойд урд хэсгүүдэд аж ахуй болон конторын өрөөнүүд болон үзвэрийн "А" болон бэлтгэлийн "Б" заалуутдтай, дунд хэсэгт байрлах гол корпус нь 4 давхар 1-р давхарт вестибиоль, аж ахуйн өрөөнүүд, 2-р давхарт эмнэлэг, 3-р давхартаа Биеийн тамир, спортын газрын оффисын өрөө тасалгаанууд, 4 давхарт тамирчдад зориулсан буудал байрладаг, барилга нь дээд түвшиндээ төмөр бетон бүстэй бетонон суурьтай, тоосгон ханатай, заалнууд 2 налуутай төмөр ферм хучилттай, төмөр болон хар цаасан дээвэртэй, 1961 онд төвийн цэвэр усан хангамжинд, дулааны шугам сүлжээг 1972 онд төвлөрсөн дулааны шугамд холбосон, бүх корпусын халаалт систем нь дээрээс түгээлттэй хоёр хоолойт систем байна.

011105012395

Барилгын баруун талд аркууд төлөвлөсөн байсан бөгөөд 1971 онд УБЗТИ-ийн боловсруулсан өргөтгөлийн 3416 тоот шифр бүхий зураг төслийн дагуу хэсэгт өргөтгөл хийж бокс, чөлөөт бөх, фитнесийн заалуудыг нэмж төлөвлөж барьжээ.

1976 онд хойд хэсэгт байрлалтай бэлтгэлийн зал шатаж дээвэр нурж унасан бөгөөд 1977 онд УБЗТИ-ийн ОСИБЗТ-нд засварын зураг төсөл боловсруулсны дагуу 1982 онд заалыг засварласан байна.

Ашиглалтанд орсноос хойш тухайн барилгын даацын хийцүүд болон халаах хэрэгсэл, цэвэр ус хангамж, ариутгах татуургын шугам, тоноглол, цахилгаан холбооны монтажид их засвар хийгээгүй байна.

Халаалтын түгээх болон босоо шугамыг 1999 онд сольсон, 2003-2004 онд дээвэр, нүүр тал, ар талын аркуудад хэсэгчилсэн засвар, фитнес, бокс, чөлөөт бөхийн заалуудад засварын ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Шалгалтаар дараах зөрчлүүд илэрч байна.

1. Барилга он удаан жил ашиглагдсан барилгын даацын үндсэн хийцүүд их муудсан, даацын гадна хануудад ан цав үүссэн, Биеийн тамир, спортын газар байрлах хэсэгт даацын хануудад их хэмжээгээр хагарал ан цав үүссэн, олон газар заалын адрын хучилтын модон хийцүүд өмхөрч муудсанаас дээврийн хөндийгөөр /чертак/ явж үйлчилгээ хийхэд хүндрэлтэй болсон,

2. Дээврийн ус тусгаарлах чанар алдагдснаас адрын хучилтаар бороо, цас хайлах үед ус их хэмжээгээр нэвчиж дулаалгын материал болон хучилтын даацын модон хийцүүдийн чанарт сөрөгөөр нөлөөлөх болсон, модон парапетууд өмхөрч ялзарч муудсан,

3. Галын усны шугам огт ажиллаагаагүй, "төв корпус, "А", "Б", " чөлөөт бөх, бокс фитнесийн бэлтгэлийн заалуудын ОХУ-д үйлдвэрлэсэн М-140 А маркын ширмэн халаах хэрэгсэл нь олон жил ашигласнаас элэгдэлд орж цоорч ус алдах үзэгдэл байнга гардаг, цэвэр ус хангамж, ариутгах татуургын шугам, сантехникийн тоноглолд их засвар хийгээгүй зэргээс шалтгаалж шугам сүлжээ цоорч гэнэт ус алдаж барилгын хана, таазыг гэмтээдэг, зарим шугам хоолой хананд болон шалны доор далд хийгдснээс засварлахад хугацаа алдах хүндрэлүүд гардаг байна.

4. Цахилгааны далд монтажын утас нь он удаан жил ашиглагдаж шинэчлэгдээгүй, бороо, цасны ус орсноос гэмтэж богино холбоо үүссэнээс 2-р давхарын коридорт хучилтын хэсэгт гол гарч байсан байна Тъурсан хэсгүүдэд ил монтажыг хэсэгчлэн засварласан, цуглуулах самбар, ерөнхий щитний ерөөнд зд зүйл хураасан, үүдний вентиляторын утас модон хийц хэсэг дээгүүр гарсан,

газардуулгын эсэргүүцлийн хэмжилт хийлгээгүй, оршиж ажиллуулдагүйгээс засвар тортолтын ажил хийдэггүй, ажлын зорилтуудыг шугам дээгүүр цахилгааны утас татсан зэрэг зөрчлүүд байгаа нь "Барилгын тухай" хуулийн 30-р зүйлийн 30.1.3-д "Хэрэглэгч нь техникийн ашиглалтын төслийн төсөлд" аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөнө", 30.1.8-д "Хэрэглэгч нь техникийн ашиглалтын төслийн төсөлд" эзэмшлийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн, аюулгүй байдал, засвар үйлчилгээ, баталгаажуулалтыг бүрэн хариуцна" заалтыг зөрчиж байна.

5. "А", "Б" заалны дээвэрт бохир агаар гаргах (зайлуулах) зориулалттай сэнснүүд таазанд суурилагдсан ба уг сэнснүүд нь ажиллахгүй, агаар оруулах систем угсралаагүй байлаа.

6. Барилгын хойд жигүүрийн 1, 2-р давхарт зориулалтын бус өрөө тасалгаануудад Биеийн тамирын дунд сургууль үйл ажиллагаа явуулж байна.

6. Бэлтгэлийн заалуудын агаар гаргах (зайлуулах) зориулалттай сэнснүүд таазанд, агаар халааж оруулах зориулалттай ус халаагч (калорифер), сэнснүүд гадна хананд тус тус суурилуулсан боловч цахилгааны шугам, халуун усны шугамын холболтыг тасалсан учир ажиллуулах боломжгүй, бэлтгэлийн явцад их бүгчим, тамирчдын эрүүл мэндэд сөрөгөөр нөлөөлөх нөхцлийг бүрдүүлсэн, үзвэрийн заалны анх төлөвлөсөн судллын тоог тооцоо судалгаагүйгээр нэмснээс уралдаан тэмцээний үед агаар хангамж их хэмжээгээр дутагддаг, үзэгчдэд зориулагдсан ариун цэврийн өрөө тасалгаа үзэгчид үйлчлүүлэгчдийн ачааллыг даахгүй болсон зэрэг зөрчлүүд нь "Барилгын тухай" хуулийн 9-р зүйлийн 9.1.1-д "барилга байгууламж нь хүн ажиллаж, амьдрах таатай нөхцөл бүрдүүлсэн, түүний эрүүл мэндэд серөг нөлөөгүй, аюулгүй байдлыг хангасан байна" заалт,

7. "Төв корпус", "А", "Б", чөлөөт бөх, бокс, фитнесийн заалуудын халаалтын системийн ширмэн халаах хэрэгсэл, цэвэр ус хангамж, ариутгах татуургын шугам, сантехникийн тоноглолууд, агаар гаргах (зайлуулах), агаар халааж оруулах зориулалттай сэнснүүд нь ашиглалтын шаардлага хангахгүй байгаа нь "Барилгын тухай" хуулийн 20-р зүйлийн 20.2 -д "Өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нь барилга байгууламжид эвдрэл, гэмтэл учруулах, зохих мэргэжлийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр бүтээц, төлөвлөлт, зориулалтыг өөрчлөх, тухайн барилга байгууламж дотор байгаль орчин, хүний амь нас, эрүүл мэндэд серөг нөлөө үзүүлж ашиглалтын хэвийн нөхцлийг алдагдуулж болзошгүй үйл ажиллагаа явуулахыг хориглоно" заалтуудыг зөрчжээ.

БАРИЛГЫН ИНЖЕНЕРИИМ

ШААРДЛАГА ХАНГАХГҮЙ, АЖИЛЛАДАГ

УЧДСЭН ХИЙШҮҮЛДЭР

ТЭХНИК, ЦАХИЛГААНЫ ШУГАМ, САЛХИВЧИЙН СИСТЕМ

ХИЙГДЭХ ИХ ЗАСВАР, ШИНЭЧЛЭЛИЙН АЖИЛ БАРИЛГА АШИГЛАЛТАНД ОРСНО

ХИЙЖ БАЙГААГҮЙГЭЭС СПОРТЫН ОРДНЫ БАРИЛГА НЬ ЦААШДЫН АШИГЛАЛТЫН МАС

ХАНГАХГҮЙ БОЛСОН БАЙНА.

Хувийг: 1. Спортын төв ордны захиргаанд

БАРИЛГЫН ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН  
УЛСЫН БАЙЦААГЧ

Л.БАТХҮҮ



БАРИЛГЫН ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН  
УЛСЫН БАЙЦААГЧ

Б.БАТЗОРИГТ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЯНАЛТЫН  
УЛСЫН БАЙЦААГЧ

С.ЗОРИГСАЙХАН

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЯНАЛТЫН  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

ЦАГААНЦООЖ